ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 10 сарын 17 өдөр | Дугаар А/659 | Улаанбаатар хот

Навигацийн үзлэг явуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.6 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.11.1.3, 2.11.2 болон Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа алба, салбаруудын агаарын навигацийн болон нисэх буудлуудын үйлчилгээний бэлэн байдлыг шалгах навигацийн үзлэг зохион байгуулах журмын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа төвийн алба, салбаруудын техник, тоног төхөөрөмж, аэродром, барилга байгууламжийн ашиглалтыг хавар-зуны ашиглалтаас намар-өвлийн ашиглалтад шилжүүлсэн үйл ажиллагааны бэлэн байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, хуваарийг хавсралтаар батлагсугай.

2. Алба салбарын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлсэн төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын байрны тодорхойлолтын дагуу ажил үүргээ гүйцэтгэсэн, удирдах дээд байгууллагаас хүргүүлсэн албан даалгавар болон үүрэг даалгаврын биелэлтийг хангасан тус газрын харьяа алба салбарын болон орон нутгийн нисэх буудлуудын дарга, ажилтнуудад үнэлэлт, дүгнэлт өгч ажиллахыг комиссын дарга нарт үүрэг болгосугай

3. Навигацийн үзлэгийг "Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа алба, салбаруудын агаарын навигацийн болон нисэх буудлуудын үйлчилгээний бэлэн байдлыг шалгах навигацийн үзлэг зохион байгуулах журам"-ын дагуу 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хооронд зохион байгуулж, үр дүн, тайланг 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулахыг Нисэх буудлуудын удирдах газар /Д.Эрдэнэбаатар/, Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газар /Ё.Эрдэнэбат/-т тус тус даалгасугай.

4. Навигацийн үзлэгийг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг төсвийн дагуу зарцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА Л.БЯМБАСҮРЭН

C:My documents\TUSHAAL\2018 on\navigatsi.docx

08 373

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн
А/659 дугаар тушаалын хавсралт

## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВИЙН АЛБА, САЛБАРУУДАД НАВИГАЦИЙН ҮЗЛЭГ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУВААРЬ

| № | Ажлын хэсгийн дарга | Гишүүд | Албан тушаал | Чиглэл | Хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ё.Эрдэнэбат АНБЗГ-ын дарга | С.Мөнхнасан | НБУГ-ын дэд дарга | "Чингис хаан" ОУНБ | 5 хоног |
| | | Д.Цогням | НБУГ-ын Үйлдвэрлэл хариуцсан ерөнхий менежер | ГТҮА | |
| | | Б.Алтантуяа | НБУГ-ын ДХТ-ийн дарга | УБХОУШНБАӨЗА | |
| | | Э.Мөнхцэцэг | НБУГ-ын ҮҮХ-ийн ахлах мэргэжилтэн | | |
| | | Д.Мөнхтөр | НБУГ-ын ДХТ-ийн ахлах мэргэжилтэн | АБХА | |
| | | Д.Сувдаа | НБУГ-ын БТХ-ийн мэргэжилтэн | | |
| | | Х.Бадмаараг | НБУГ-ын БТХ-ийн мэргэжилтэн | | |
| | | Б.Эрдэнэбаатар | НБУГ-ын ҮҮХ-ийн инженер | | |
| | | Л.Оюунтуяа | НБУГ-ын ҮҮХ-ийн мэргэжилтэн | | |
| | | И.Амарсанаа | НБУГ-ын ДХТ-ийн ахлах мэргэжилтэн | | |
| | | Х.Бямбацогт | НБУГ-ын ҮҮХ-ийн мэргэжилтэн | | |
| | | П.Баатар | ХНАА-ны ахлагч инженер | | |
| | | Т.Төгсбаяр | НБУГ-ын ДХТ-ийн инженер | | |
| 2 | Д.Эрдэнэбаатар НБУГ-ын дарга | П.Гантөгс | АНБЗГ-ын үйлдвэрлэл хариусан менежер | НХҮАлба<br>ХНААлба<br>НМҮАлба | 5 хоног |
| | | Н.Батсайхан | АНБЗГ-ын бодлого хариуцсан менежер | НЖБАлба | |
| | | Д.Лхагважав | АНБЗГ-ын ахлах мэргэжилтэн | НУТАлба | |
| | | М.Эрдэнэсүх | АНБЗГ-ын техникийн бодлого хариуцсан мэргэжилтэн | | |
| | | Х.Одхүү | АНБЗГ-ын нисэхийн мэдээллийн үйлчилгээний мэргэжилтэн | НСТ-ийн Дадлагажуурын хэсэг | |
| | | Д.Уртнасан | АНБЗГ-ын мэргэжилтэн | | |
| | | Т.Хадбаяр | АНБЗГ-ын мэргэжилтэн | | |

- - - o O o - - -